МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН ЯАМ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР САНГИЙН ЯАМ

ЦЭЦЭРЛЭГ, ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ, ДОТУУР БАЙРЫН УС, АРИУН ЦЭВЭР, ЭРҮҮЛ АХУЙД ТАВИГДАХ НОРМ, ШААРДЛАГА

2015 он

unicef
НҮБ-ын Хүүхдийн Сан

Монгол дахь НҮБ-ын Хүүхдийн сангийн Ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн хөтөлбөрийн дэмжлэгээр боловсруулав.

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД, ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙД, САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2015 оны 06 сарын 29 өдөр Дугаар А/253/251/173 Улаанбаатар хот

Норм, шаардлага батлах тухай

Боловсролын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын ус, ариун цэвэр, эрүүл ахуйд тавигдах норм, шаардлагыг хавсралт ёсоор баталсугай.

2. Норм, шаардлагыг жил бүрийн батлагдсан төсөвт багтаан хэрэгжүүлэх, аймаг, дүүрэг бүрт цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байранд ус, ариун цэвэр, эрүүл ахуйн норм, шаардлагыг хангасан загвар орчин байгуулах, арга зүйн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (Д.Эрдэнэчимэг), Санхүү, хөрөнгө оруулалтын газар (Ц.Баярхүү), Эрүүл мэнд, спортын яамны Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (О.Баяр)-т тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс (М.Оюунцэцэг), Эрүүл мэнд, спортын яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Э.Оюунсүрэн), Сангийн яамны Төсвийн хяналт, эрсдлийн удирдлагын газарт тус тус даалгасугай.

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД
Л.ГАНТӨМӨР

ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙД
Г.ШИЙЛЭГДАМБА

САНГИЙН САЙД
Ж.ЭРДЭНЭБАТ

БСШУ-ны сайд, ЭМС-ын сайд, Сангийн сайдын 2015 оны А/253/251/173 тоот хамтарсан тушаалын хавсралт

ЦЭЦЭРЛЭГ, ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ, ДОТУУР БАЙРЫН УС, АРИУН ЦЭВЭР, ЭРҮҮЛ АХУЙД ТАВИГДАХ НОРМ, ШААРДЛАГА

Нэг. Унд, ахуйн ус хангамжид тавигдах шаардлага

1.1. Ундны усны хангамжид тавигдах шаардлага

Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрт:

1.1.1. Ундны ус нь үндэсний стандартын шаардлагыг хангасан байх.
1.1.2. Усны чанар, аюулгүй байдалд жилд 2-оос доошгүй удаа шинжилгээ хийлгэж, дүгнэлт гаргуулах.
1.1.3. Төвлөрсөн болон төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэртэй байна. Усны эх үүсвэрт эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг 50 метрээс доошгүй зайд тогтоож, дэглэмийг мөрдөх.
1.1.4. Сургууль, цэцэрлэгт хүүхэд бүр өдөрт 1 литрээс доошгүй ундны цэвэр ус уух боломжоор хангагдсан байх.
1.1.5. Ундны ус зөөх, хадгалах сав нь таглаатай, угааж цэвэрлэхэд хялбар, хүнсний зориулалтын материалаар хийгдсэн, хүүхдийн эрүүл мэндэд эрсдэлгүй байх.
1.1.6. Ундны ус хадгалах савыг 7 хоногт 1-2 удаа бүрэн суллаж, угааж, халдваргүйтгэх.
1.1.7. Сурагчид хувийн аяга болон ундны ус уух савтай байх.

Сургуулийн дотуур байрын нэмэлт шаардлага

1.1.8. Дотуур байрын сурагч бүр өдөрт 2 литрээс доошгүй ундны ус уух боломжоор хангагдсан байх.

1.2. Ахуйн хэрэглээний ус хангамжид тавигдах шаардлага

Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрт:

1.2.1. Сурагч бүр хувийн ариун цэвэр сахихад 6-7 литр усны хангамжтай байх.
1.2.2. Усаар зайлуулдаг бие засах газартай сургуулийн сурагчид өдөрт 10-15 литр усны хангамжтай байх.
1.2.3. Ил задгай усны эх үүсвэр нь жорлон болон бохир ус, ариутгах татуургын ус зайлуулах хоолойноос хөрсний байдлаас шалтгаалан наад зах нь 30-50 метр хол байх.
1.2.4. Угаалга цэвэрлэгээний ус авах газар нь бага ангийн сурагчид, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ойр, тохиромжтой, хүртээмжтэй байх.

1.2.5. Угаалга цэвэрлэгээний газар бүрт ус зайлуулах байнгын ажиллагаатай хоолой болон бохир усны цооногтой байх.

Сургуулийн дотуур байрын нэмэлт шаардлагууд

1.2.6. Хүүхэд бүр гар угаах, усанд орох болон бусад хэрэглээндээ өдөрт 20 литр усны хангамжтай байх.

Хоёр. Ариун цэврийн байгууламжид тавигдах шаардлага

2.1. Ариун цэврийн байгууламжийг төлөвлөх, барихад тавигдах шаардлага

Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрт:

2.1.1. Нэг ээлжинд хичээллэж буй 30 эмэгтэй хүүхдэд 1 суултуур, 40 эрэгтэй хүүхдэд 1 суултуур + 1 шээлтүүр ногдохоор тооцож байгуулах.
2.1.2. Ариун цэврийн өрөө нь хүүхдийн нас, хүйсийн онцлогт тохирсон, хүүхдэд ээлтэй байх.
2.1.3. Эрэгтэй/эмэгтэй хүүхэд болон багш, ажилчдад зориулсан ариун цэврийн өрөө тусдаа байх.
2.1.4. Сургууль болон дотуур байрны ариун цэврийн өрөөнд явган суултуур суурилуулж болно.

2.1.5. Гадна жорлон нь хэрэглэгчээс 30 метрийн дотор байрлах бөгөөд улирлын ямар ч нөхцөлд ашиглагдахуйц байх.
2.1.6. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлогт тохирсон нэг жорлонтой байх.
2.1.7. Гадна жорлон нь зохих ёсны агааржуулагч, гэрэлтүүлэг, доторлогоо, дотроосоо түгждэг цоожтой, таглаатай хогийн савтай байх.

Цэцэрлэгийн нэмэлт шаардлага

2.1.10. Цэцэрлэг болон бага сургуулийн сурагчдад зориулсан ариун цэврийн өрөөг дотор байгуулах.
2.1.11. Цэцэрлэгийн 15-аас ихгүй хүүхдэд, бага ангийн 30 сурагчдад нэг суултуур тус тус ногдохоор тооцож байгуулах.

2.1.12. Хөтөвч ашигладаг хүүхэд бүр тусдаа хөтөвчтэй байх.
2.1.13. Суултуур, шээлтүүр нь хүүхдийн нас, өндөрт тохирсон хийцтэй, хэрэглэхэд хялбар байх.

Шилжилтийн насны охидод зориулсан нэмэлт шаардлага

2.1.15. Ариун цэврийн хэрэглэл бусад хог хаягдлыг хаях тагтай хогийн савтай байх.
2.1.16. Дотуур байранд охидын хувцсаа угаах, солиход нь зориулсан хаалгатай тусгай угаалгын өрөө байх ба шаардлагатай үед угаалга цэвэрлэгээндээ хэрэглэх цэвэр усаар хангагдсан байх.

2.1.17. Охидын угаалга болон хувцас солих өрөөний хогийн савыг өдөр тутам цэвэрлэж, хаягдлыг аюулгүй зайлуулж байх.

2.2. Ариун цэврийн байгууламжийн ашиглалт ба байнгын ажиллагааг хангах талаар

Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрт:

2.2.1. Суултуур/шээлтүүрийн засвар үйлчилгээ, цэвэрлэгээг цаг тухайд нь хийж, эвдрэл гэмтэлгүй, цэвэр байлгах (муухай үнэргүй, ялаагүй, ил задгай бие засаагүй).
2.2.2. Ариун цэврийн цаас болон цэвэрлэгээний бусад материалыг хүртээмжтэй байлгах.
2.2.3. Ариун цэврийн өрөө нь завсарлага болон хичээлийн үед ч ашиглаж болох байнгын ажиллагаатай байх.
2.2.4. Ариун цэврийн өрөөний хаалга, бариул нь бага насны болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд тохиромжтой байх.
2.2.5. Цэвэрлэгээ халдваргүйтгэл тогтмол хийх.

Цэцэрлэгийн нэмэлт шаардлага

2.2.6. Бага насны хүүхдийн хөтөвчийг хэрэглэх бүрт угааж цэвэрлэх, халдваргүйтгэх.

Гурав: Гар угаагуур болон шүршүүрт тавигдах шаардлага

3.1. Гар угаах байгууламж

Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрт:

3.1.1. Сургууль: 40 сурагчид нэг гар угаах угаагуур ногдохоор тооцож байгуулах.
3.1.2. Дотуур байр: 30 сурагчид нэг гар угаах угаагуур ногдохоор тооцож байгуулах.
3.1.3. Цэцэрлэг, сургууль, дотуур байранд хүүхдүүд бүлээн усаар гараа угаах нөхцлөөр хангагдсан байх.
3.1.4. Гар угаах угаагуур бүрийн дэргэд саван тогтмол байлгах.
3.1.5. Гар угаах байгууламж нь бага насны сурагчид, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд ойр, тохиромжтой, хүртээмжтэй байх.
3.1.6. Гар угаах угаагуурын хажууд алчуур/ гар хатаагч болон таглаатай хогийн сав байрлуулах.

Цэцэрлэгийн нэмэлт шаардлага

3.1.8. Цэцэрлэг: 20-оос ихгүй хүүхдэд нэг гар угаах угаагуур ногдохоор тооцож байгуулах.

3.1.9. Гар угаах угаагуурыг дотор байрлуулах ба халуун, хүйтэн усны холигчтой байх.

3.1.10. Гар угаах угаагуур нь хүүхдийн өндөрт тохирсон байх.

3.1.11. Угаалга цэвэрлэгээний бодис, хэрэглэгдэхүүнийг хүүхдийн гар үл хүрэх түгжээтэй шүүгээнд хадгалах.

Сургуулийн дотуур байрын нэмэлт шаардлага

3.1.12. Гадна жорлонтой сургуулийн дотуур байрны гар угаах угаагуурыг дотор байгуулах.

3.1.13. Хоолны газрын дэргэд гар угаагуурыг байгуулах.

3.2. Усанд орох онгоц, шүршүүр

Сургуулийн дотуур байрт

3.2.1. Охид, хөвгүүд тус тусдаа усанд орох боломжоор хангагдсан байх.

3.2.2. 20 охид, хөвгүүд тутамд нэг шүршүүр ногдохоор тооцож байгуулах.

3.2.3. Хөгжлийн бэрхшээлтэй охид, хөвгүүдэд зориулсан тохиромжтой шүршүүр бүхий өрөө 1-ээс доошгүй байх.

3.2.4 Саван бусад тоног төхөөрөмжөөр хангагдсан угаалгын өрөөтэй байх.

Дөрөв. Ус, ариун цэвэр, эрүүл ахуйн байгууламжийн засвар үйлчилгээнд тавигдах шаардлага

Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрт:

4.1. Ус, ариун цэвэр, эрүүл ахуйн байгууламжид засвар үйлчилгээг хийх төлөвлөгөөтэй, төлөвлөгөөний дагуу засвар үйлчилгээ хийдэг байх.

4.2. Ариун цэврийн байгууламжийн цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн материал худалдаж авах, ашигласан усны төлбөр төлөх зэрэг бусад шаардлагатай үйлчилгээнд зарцуулах төсөвтэй байх.

4.3. Сургуулийн дотоод болон гадаад орчныг тогтмол цэвэрлэж байх (хог хаягдал, бохир усыг цаг тухайд нь аюулгүй зайлуулах, мөсөн бүрхүүлгүй байлгах).

Тав. Эрүүл ахуйн боловсрол, зан үйлийн өөрчлөлтөд тавигдах шаардлага

5.1. Эрүүл ахуйн боловсрол

Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрт:

5.1.1. Эрүүл ахуйн боловсрол нь сургалтын хөтөлбөрийн салшгүй хэсэг байх ба

ариун цэврийн өрөөг хэрхэн ашиглах, гар угаах, шүд угаах, хог хаягдал зэрэг агуулгыг багтаасан байх.

5.1.2. Эрүүл ахуйн боловсрол олгоход шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүн, материал нь хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон, хүртээмжтэй байх.

5.1.3. Сургууль (дотуур байр) бүр ус, ариун цэвэр, эрүүл ахуйн асуудлыг хариуцсан ажилтантай байх.

5.1.4. Эрүүл мэнд болон ус, ариун цэвэр, эрүүл ахуйн клубуудыг сургууль дээр байгуулж, идэвхтэй ажиллуулах.

5.1.5. Эцэг эх, асран хамгаалагчдад ариун цэвэр, эрүүл ахуйн чиглэлээр сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулж, хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулдаг байх.

5.1.6. Ариун цэвэр, эрүүл ахуйн чиглэлээр хичээлээс гадуурх үйл ажиллагаа зохион байгуулах.

5.1.7. Сурагчдын мэдлэг, хандлага, зан үйлийн өөрчлөлтийг хянаж үнэлэх дотоод хяналтын тогтолцоотой байх.

Сургуулийн дотуур байрын нэмэлт шаардлага

5.1.9. Жендерийн болон нөхөн үржихүйн асуудал нь хичээлээс гадуурхи сургалтын хэсэг байх.

5.1.10. Хүүхдэд эрүүл мэндийн сургалт, сурталчилгаа явуулах болон үйлчилгээ үзүүлэх өрөөтэй байх.

5.1.11. Сургалтад хамрагдсан ажилтан өсвөр насны охид, хөвгүүдэд бие бялдрын өсөлт хөгжил, бие махбодийн өөрчлөлтийн талаар зөвлөгөө өгдөг байх.

5.1.12. Охид сарын тэмдгийн хуанли хөтлөх, ариун цэврийг сахих талаар зөвлөж, дэмждэг байх.

5.2. Эрүүл ахуйн дадал, зан үйлийн өөрчлөлт

Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрт:

5.2.1. Ил задгай бие засахгүй, хог хаяхгүй байх.

5.2.2. Суултуур/шээлтүүрийг зөв ашигладаг байх.

5.2.3. Гараа савандаж угаах дадал хэвшилд суралцсан байх.

5.2.4. Гараа савандаж угаахын ач холбогдлыг ойлгосноор бусдад зааж сургадаг, сурталчилдаг байх.

5.2.5. Эцэг эхийн зөвлөл нь олон нийттэй хамтран жилд нэгээс доошгүй удаа эрүүл ахуйн талаарх мэдлэг сайжруулах талаар ажил зохион байгуулдаг байх (сургуулийн урлагийн тоглолт, жүжиг гэх мэт).

Зургаа. Гал тогоо болон хоол хүнс боловсруулахад тавигдах шаардлага

Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрт:

6.1. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн хүлээн авах хэсэг, хүнсний бүтээгдэхүүн хадгалах төрөлжсөн агуулах, бэлтгэлийн өрөө, халуун хоол боловсруулах өрөө, гурилан бүтээгдэхүүнээр үйлчилдэг бол нарийн боовны өрөө, халуун хоол олгох хэсэгтэй, технологийн урсгал дамжлагыг баримталсан, гал тогооны хүчин чадалд хүрэлцэхүйц бүрэн ажиллагаатай тоног төхөөрөмжөөр тоноглогдсон, багш, ажилчидаас тусдаа хувцас солих өрөө, ариун цэврийн болон шүршүүрийн өрөөтэй байх.

6.2. Гал тогооны өрөөний шал, хана, таазыг ус нэвтэрдэггүй, бат бөх, тэгш гөлгөр гадаргуутай, өнгө үзэмж сайтай, цэвэрлэхэд хялбар, сайн чанарын материалаар хийж, хортон шавж, бичил биетэн үржихээс хамгаалах өрөө тасалгаанд агааржуулагч, тоног төхөөрөмж бүрд агаар сэлгэлтийн систем байрлуулах бөгөөд гал унтраах хэрэгслүүдийг нүдэнд ил харагдах газарт байрлуулах.

6.3. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хэсэг нь сайжруулсан усан хангамжтай, бохир ус зайлуулах цооногтой байх бөгөөд гадна жорлон, хог хаягдлын цэг, бохирын эх үүсвэрээс хол байгуулах.

6.4. Хүүхдийн хоол хүнсэнд хэрэглэх ундны цэвэр ус нь стандартын шаардлага хангасан, гүний болон тээвэрлэн зөөвөрлөж ирсэн усыг стандартад нийцүүлэн шүүлтүүрт шүүсний дараа хоол хүнсэнд хэрэглэх.

6.5. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний ажилчдад гар бохирдох бүрт, хүүхдүүдэд хооллохын өмнө гар угаах, ариутгах орчин нөхцөлийг эрүүл ахуйн шаардлагад нийцүүлэн бүрдүүлэх.

6.6. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг орон нутгийн мэргэжлийн хяналтын байгууллагын зөвшөөрөл бүхий худалдаа, үйлчилгээний байгууллагатай гэрээ хийж сав, баглаа боодол дээрх үйлдвэрлэгчийн нэр хаяг, үйлдвэрлэсэн он сар өдөр, цаг, хадгалах хугацаа, нөхцөл зэргийг шалган авч байх.

6.7. Түргэн гэмтэх түүхий эд, бүтээгдэхүүн /мах, сүү, өндөг г.м-ийг/ зориулалтын хөргөгч, хөргүүртэй агуулахад хадгалах, түүхий болон болсон хоол хүнсийг хооронд нь холих, хамт хадгалахаас зайлсхийх, шууд хэрэглэх бэлэн бүтээгдэхүүн, болгож бэлтгэсэн хоол хүнсийг 2 цагийн дотор олгох, болгож хонуулсан хоолыг хүүхдийн хоолонд дахин ашиглахгүй байх.

6.8. Хүүхдийн аманд орж байгаа бүхий л хоол хүснээс дээж авах /чихэр, боов, хавчуургатай печень, хоол, шүүс, ундаа, цай/. Олгож буй хоолноос 250-500гр хүртэл, ширхэгийн бүтээгдэхүүн бол хүүхдэд өгч буй хэмжээгээр дээжийг авч 48-72 цаг хадгалж устгана.

6.9. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний ажилчид ажлын дүрэмт хувцас (өмсгөл, малгай, хормогч, ажлын гутал өмсөж гарын алчууртай)-аа бүрэн өмсөж, бөгж, бугуйвч, цаг зүүгээгүй, хумс ургуулаагүй, хумсны будаггүй, эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд жилд хоёр удаа хамрагдах ба хэрэв халдварт өвчний нян тээгч илэрсэн тохиолдолд эрүүлжүүлэх арга хэмжээ авах, өвчин илэрвэл заавал эмчлүүлэх.

6.10. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хэсгийн шал, хана, хаалгыг өдөр бүр цэвэрлэж, цэвэрлэгээг хийж дууссаны дараа ариутгалын бодистой халуун усаар халдваргүйжүүлэн, цэвэрлэгээний багаж хэрэгслийг тусгай байранд хадгалах.

6.11. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд хэрэглэсэн багаж хэрэгсэл, сав суулгыг зориулалтын угаалгын шингэнээр угааж, ариутгах.

6.12. Мэргэжлийн байгууллагаар улирал тутам хортон шавж, мэрэгчийн устгал, халдваргүйжүүлэлтийн ариутгал хийлгэх.

6.13. Хог хаягдлыг шинж чанараар нь зориулалтын таглаатай саванд ангилан цуглуулж, хогийн цооног, хог цуглуулах цэгт хаях.

Долоо. Хатуу хог хаягдал, бохир усыг зайлуулах менежментэд тавигдах шаардлага

Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрт:

7.1. Ариун цэврийн өрөө бүрт тагтай хогийн сав байрлуулах.

7.2. Цэцэрлэг, сургууль бүр хатуу хог хаягдлыг цуглуулж хаях хогийн цэгтэй байх.

7.3. Цэцэрлэг, сургууль, дотуур байр нь хог хаягдлын цуглуулах, зайлуулах талаар холбогдох хууль, дүрэм, журмыг мөрдөх.

7.4. Цэцэрлэг, сургуулийн хогийн цооног, хог цуглуулах цэг нь сургуулиас болон усны эх үүсвэрээс 100 метр, барилга байгууламжаас 30 метрээс доошгүй зайд байрлах ба хана, хашаагаар тусгаарлагдсан битүүмжлэл сайтай хаалттай байх.

7.6. Хэсгийн цэвэрлэх байгууламжтай тохиолдолд цэвэрлэгдсэн ус нь үндэсний стандартын шаардлагад нийцсэн байх.

7.7. Бохирын цооногтой бол холбогдох дүрэм журамд заасны дагуу бохир усыг соруулан зайлуулах

***